



**ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Төлөвлөгөөг үнэлсэн:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА

.....

(Т.РЭНЧИНВАНЖИЛ)

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....

(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

.....

(П.МӨНХЗАЯА)

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг

.....

(огноо)

№	Дэд салбар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ						Дундаж хувь
				70%	82,3%	85,9%	90%	94,6%	100%	
1.	Бодлогын баримт бичиг тусгагдсан зорилт, арга хэмжээ	3	14	-	-	-	-	-	14	100
2.	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, зорилт арга хэмжээ (Тусгай)	4	10	-	-	-	-	-	10	100
3.	Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, зорилт арга хэмжээ (Нийтлэг)	5	26	-	1	1	2	-	22	98
4.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт арга хэмжээ	2	8	-	-	-	-	1	7	99.3
Нийт		14	58	-	1	1	2	1	53	99.3

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилт, арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
Зорилт 1.1.Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
1.1.1	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутагтай хамааралтай 2024 оны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БӨХ	Арга хэмжээний тоо	18	18	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн захиргааны удирдлагын хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлэн хэрэгжилтийг zavkhan.igovernment.mn цахим системд цаг тухай бүрт нь тайлагнан холбогдох хэлтэст хүргүүллээ.	100.0
1.1.2	Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангана.	БӨХ	Арга хэмжээний тоо	120	120	Завхан аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Засаглалын бодлоготой холбоотой зорилт арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр zavkhan.igovernment.mn цахим системд тайлагнан холбогдох хэлтэст хүргүүллээ. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2024 оны хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн биелэлт 78.08 хувьтай дүгнэгдсэн байна.	100.0

1.1.3	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	БӨХ	Арга хэмжээний тоо	287	287	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлоготой холбоотой зорилт арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр zavkhan.igovernment.mn цахим системд тайлагнан холбогдох хэлтэст хүргүүллээ. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн биелэлт 85,51 хувьтай дүгнэгдсэн байна.	100.0
1.1.4	Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.	БӨХ	Арга хэмжээний тоо	188	188	Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан Засаглалын бодлоготой холбоотой зорилт арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг тухай бүр нь тайлагнан Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа. Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн биелэлт 92,29 хувьтай дүгнэгдсэн байна.	100.0
1.1.5	Оны тэргүүний албан хаагч, шилдэг сум, шилдэг баг, шилдэг байгууллагыг шалгаруулна.	ОНТ	Оны тэргүүнээр шалгарсан сум, багийн тоогоор	Албан хаагч 9, "Шилдэг сум" 3, "Шилдэг баг" 3, "Шилдэг байгууллага" 3	Албан хаагч 9, "Шилдэг сум" 5, "Шилдэг баг" 5, "Шилдэг байгууллага" 5	Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, холбогдох журам заавруудыг үндэслэн "Шилдэг сум" 4, "Шилдэг баг" 1, "Шилдэг байгууллага" 3, Тэргүүний албан хаагч 9, оны онцлох хүн 2, "Шилдэг бизнес эрхлэгч" 1 шалгаруулан Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/30 захирамжаар шагнаж урамшуулсан.	100.0

1.1.6	Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 103 жил, Аймаг үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тэмдэглэнэ.	ОНХС	Төлөвлөгөөний хэрэгжилт	-	Хагас жил- 50% Бүтэн жил – 100%	Аймгийн Засаг даргын 2024 оны А/211 дүгээр захирамжаар Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 103 жилийн ой, Завхан аймаг үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойг зохион байгуулах 8 салбар хороо бүхий ажлын хэсэг байгуулагдаж төлөвлөгөөний дагуу баяр наадмын үйл ажиллагааг зохион байгуулсан.	100.0
1.1.7	“Нээлттэй-Завхан” хөтөлбөрийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулна.	ОНХС	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Хот, хөдөөгийн сэргэлтийг орон нутаг хэрэгжүүлэх зорилгоор "Нээлттэй Завхан аймаг" хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тулгуурлан боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүрээр батлан хэрэгжилтийг хангуулж байна. Аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 50.0 сая тусгаж, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг зогсоох, орон нутгийн иргэдийг хүлээн авахад шаардлагатай мэдээлэл, арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна. Мөн төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар, орон нутгаас олгох нэмэгдлийг 20 хувиар, нийт 40 хувиар олгож, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Орон нутагт шинээр байр худалдан авч буй иргэдэд ипотекийн 3 хувийн зээлийг олгож, санхүүжилтийг ханган ажилласан.	100.0
1.1.8	Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг хэвлэл	ОНХС	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо	9	15-аас доошгүй	“Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг гэрээт ТВ, сонин, сайтууд болон аймгийн цахим хуудсаар иргэдэд сурталчлах ажлыг зохион	100.0

	мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчилна.					байгуулж, ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. 2024 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр 260 гаруй, Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз, UBS телевизээр 21, UBN, Лайв, Нүүдэлчин, Мөрч зэрэг гэрээт сайтуудаар 108 удаагийн мэдээлэл нэвтрүүлж, орон нутагт зохион байгуулж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг улс орон даяар үзэгчдэд хүргэлээ.	
1.2.Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.							
1.2.1	Иргэдэд хүргэх төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлнэ.	БӨХ	Төрийн үйлчилгээг цахимаар хүлээн авсан иргэдийн хувь	15%	Хагас жил-25% Бүтэн жил-45%	Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран e-mongolia цахимд системд орон нутгийн олон шатлалт 15 байгууллагын 50 үйлчилгээг нэвтрүүлэн хэвийн ажиллаж байна.	100.0
1.2.2	E-Mongolia төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.	БӨХ	Төрийн үйлчилгээг цахимаар хүлээн авсан иргэдийн хувь	45%	Хагас жил-45% Бүтэн жил-60%	2024 онд e Mongolia төвөөр давхардсан тоогоор 11863 иргэн үйлчлүүлсэн бөгөөд лавлагаа тодоройлолт гаргаж өгсөн байна.	100.0
1.2.3	Төрийн албаны хүний нөөц дахь удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил-100% Бүтэн жил-100%	Байгууллагын батлагдсан бүтэц, орон тооны дагуу албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлт, цалин, нэмэгдэл хөлсний шинэчлэлтийг Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд тухай бүр нь оруулснаар цалингийн нэгдсэн программ татаж, албан хаагчид шинэчлэгдсэн цалинг олгох боломж бүрдсэн. Хүний нөөцийн мэдээллийн систем, цалингийн нэгдсэн	100.0

						системийн уялдаа хангагдаж, хяналт сайжирсан.	
1.3. Төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.							
1.3.1	Erp.e-mongolia төрийн удирдлагын нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулна.	БӨХ	систем нэвтрүүлсэн байгууллагын тоо	47	Хагас жил -60 Бүтэн жил-120	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И Монгол академитай хамтран Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ерp. e mongolia портал системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Өнгөрсөн онд аймгийн Засаг даргын Тамгын газар болон 100 гаруй хэлтэс агентлаг, сумдын байгууллагад нэвтрүүлсэн бол энэ онд 16 байгууллага тус системтэй холбогдоод байна.	100.0
1.3.2	Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	БӨХ	Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулсан хөрөнгийн дүн	12.5 сая төгрөг	Хагас жил-6.5 сая төгрөг Бүтэн жил-12.5 сая төгрөг	Төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, хууль тогтоомжид заасан цалингийн шатлалаар цалинжуулж, нэмэгдэл хөлсийг тухай бүрт олгож байна. Тухайлбал, хоолны өдрийн хөнгөлөлтийг 20000, унааны өдрийн хөнгөлөлтийг 5000 төгрөг болгож нэмэгдүүлж, орон нутагт ажилласны нэмэгдлийг 40 хувиар олгодог болсон. Мөн төрийн захиргааны 25 албан хаагчдад 5 жил тутамд нэг удаагийн мөнгөн урамшууллыг олгосон. Орон сууцны дэмжлэг үзүүлэхээр Хөдөлмөрийн дотоод журамд заасны	100.0

						дагуу 6 албан хаагчид 6.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
1.3.3	Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна.	БӨХ	Сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн тоо	160	Хагас жил-150 Бүтэн жил-300	Төрийн албан хаагчдыг дээд шатны байгууллага, олон улсын төсөл хөтөлбөрөөс зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлгийн үйл ажиллагаанд оролцуулж, томилолтын зардлыг шийдвэрлэн ажилласан байна. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөг 3 зорилт 15 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар сургалтын төлөвлөгөө 87.0 хувийн хэрэгжилттэй байна. Жилийн эцсийн үр дүнг тооцохоор ажиллаж байна.	100.0
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
2.1.Аймгийн Засаг даргын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.							
2.1.1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргатай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан, тайлагнана.	БӨХ	Гэрээний хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил-70% Бүтэн жил-95%	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хуульд заасан төрийн зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх гэрээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар гэрээний хэрэгжилт 88.0 хувьтай дүгнэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнагдсан бол жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган боловсруулалт хийгдэж байна.	100.0

2.1.2	Гадаад харилцааны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан, тайлагнана.	БӨХ	Гэрээний хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил-70% Бүтэн жил-95%	Гадаад харилцааны сайдтай аймгийн Засаг дарга 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 100 хувьтай тайлагнан 12 дугаар сарын 01-ний өдөр гадаад харилцааны яаманд хүргүүлсэн.	100.0
2.1.3	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний холбогдох заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан, тайлагнана.	БӨХ	Гэрээний хэрэгжилтийн хувь	94,5%	Хагас жил-70% Бүтэн жил-95%	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны сайд болон аймгийн Засаг даргын хооронд 2024 онд байгуулсан гэрээний холбогдох заалтыг хяналтад авч хэрэгжилтийг хагас жилээр тайлагнан ажилласан бөгөөд жилийн эцсээр тайлагнахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100.0
2.2.Нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдыг бодлого, зөвлөгөө, мэдээллээр хангана.							
2.2.1	Нутгийн захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдыг бодлогын зөвлөгөө дэмжлэгээр хангана.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	70%	Хагас жил-70% Бүтэн жил -100%	Нутгийн захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдыг удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллалаа. Аймгийн бодлогын баримт бичгүүдэд Нутгийн захиргааны байгууллагын Засаг даргын тамгын газрын барилга, байгууламжийн шинэчлэлт, засвар хийх, авто машины парк шинэчлэлтийг үргэлжлүүлэх, сургалт зэрэг арга хэмжээг тусгуулан батлуулсан. Аймгийн Засаг даргын Тамгын газраас 24 сумын Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа, Засаг даргын Тамгын дарга нарыг чадавхжуулах сургалтыг 4 удаа, Удирдлагын академитай хамтран 24 сумын 116 багийн Засаг дарга нарыг	100.0

						чадавхжуулах сургалтыг 1 удаа, зохион байгуулсан. Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарыг БНХАУ руу туршлага судлууллаа. Мөн шинээр томилогдсон сумын Засаг дарга нарт сургалт мэдээлэл өгч ажиллаж байна.	
2.2.2	Хэлтсийн албан хаагчдыг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллана.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил– 70% Бүтэн жил - 100%	Хэлтсийн албан хаагчдыг өдөр тутмын удирдлагаар хангаж, цаг үеийн асуудалтай холбоотой үүрэг чиглэлийг өгч хяналт тавин ажиллаж, төрийн үйлчилгээний албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг сар бүр хянаж, үнэлгээг үндэслэн ур чадварын нэмэгдлийг олгон ажиллаж байна.	100.0
2.3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хурлын ажлын албатай хууль тогтоомжийн хүрээнд харилцана.							
2.3.1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн хүргүүлнэ.	БӨХ	Дэмжлэг үзүүлсэн тоо	3	Хагас жил -1 Бүтэн жил -2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн хүргүүлэн ажиллалаа.	100.0
2.3.2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг тооцож, хүргүүлнэ.	БӨХ	Биелэлтийн хувь	96.0	Хагас жил - 90% Бүтэн жил – 98%	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаан, зөвлөлийн шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100.0
2.4.Төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулан, хэрэгжилтийг хангуулна.							
2.4.1	Сумын Засаг дарга нарын аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төслийг боловсруулан гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.	БӨХ	Байгуулсан гэрээний тоо	24	Хагас жил - 24	24 сумын Засаг дарга нартаа аймгийн Засаг дарга байгуулах гэрээний төслийг бэлтгэн нэгтгэж гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.	100.0

2.4.2	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга нар аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төслийг боловсруулан гэрээ байгуулна.	БӨХ	Байгуулсан гэрээний тоо	28	Хагас жил - 28	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 29 хэлтэс, агентлагийн дарга нартай байгуулах гэрээний төслийг бэлтгэн нэгтгэж бэлэн болгон 27 дарга гэрээ байгуулсан	100.0
2.4.3	Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргаж, бэлтгэл ажлыг ханган, тэмдэглэл хөтөлж албажуулна.	БӨХ	Хурлын шийдвэрийн тоо	4	Хагас жил-2 Бүтэн жил-4	Аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 1 удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, гишүүдэд зар хүргүүлэх, хуралд оролцуулах арга хэмжээг авсан бөгөөд 1 удаагийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихаар ажиллаж байна. Хэрэгжилт 100 хувь хангагдсан.	100.0
ГУРАВ. ХУУЛИАР НИЙТЛЭГ ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 3.1.Хүний нөөцийн бодлогыг төлөвлөж, удирдлага, манлайллыг хэрэгжүүлнэ.							
3.1.1	Хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллана.	БӨХ	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хувь	92%	Хагас жил – 95% Бүтэн жил - 98%	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу хүний нөөцийн мэдээллийн ил тод байдлыг хангаж, холбогдох мэдээллүүдийг ил тод нээлттэй байрлуулан, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж байна. Тухайлбал, сул орон тооны мэдээллийг тухай бүрт танилцуулах, байгууллагын албан хаагчдын танилцуулга, холбогдох утасны дугаар зэрэг мэдээлэл цахим хуудаст байршуулсан. Төрийн цахим үйлчилгээний газраас үнэлсэн хүний нөөцийн ил тод байдлын үнэлгээгээр 84 хувьтай үнэлэгдсэн байна.	82.3
3.1.2	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийг хөтөлж,	БӨХ	Хууль тогтоомжийн	69	Хагас жил – 69	Төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтэд Төрийн албаны зөвлөлийн	100.0

	баяжуулан хууль тогтоомжийн дагуу хадгалж, архивлана.		дагуу бүрдүүлсэн хувийн хэргийн тоо		Бүтэн жил - 69	ажлын хэсэг ажиллах, Төрийн аудитын байгууллагад шалгуулах зорилгоор 2 удаа хяналт хийж, дахин бүрдүүлэх ажлыг зохион байгууллаа. Хувийн хэргийг баталсан кодын дагуу дугаарлан, зориулалтын сейфэд хадгалан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн хувийн хөтлөх журмаар баталсан загварын дагуу 74 төрийн албан хаагчдын албан тушаалын картыг томилогдсон огноог үндэслэн бичиж, баталгаажуулсан байна.	
3.1.3	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.	БӨХ	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2	Хагас жил – 3 Бүтэн жил - 5	Улсын төсвийн хөрөнгөөр төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулж байна. Тухайлбал, 1 албан хаагчийг эрхэлсэн түшмэлийн, 1 албан хаагчийг ахлах түшмэлийн, 2 албан хаагчийг дунд хугацааны мэргэшүүлэх, 2 албан хаагчийг анхан томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулж байна. Өмнөх улиралд анхан томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан 1 албан хаагч дахин судалж, амжилттай төгссөн байна.	100.0
3.1.4	Аймгийн хүний нөөцийн бодлого, чиглэлийг Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, хяналт тавина.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100	Хагас жил – 60 Бүтэн жил - 100	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах талаар чиглэл хүргүүлэн ажиллаж байна.	100.0

3.1.5	Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг журмын дагуу зохион байгуулж, тайлагнана.	БӨХ	Шалгалт зохион байгуулсан тоо	4	Хагас жил – 4 Бүтэн жил -6	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл 2024 онд 8 удаа тусгай шалгалтыг зохион байгуулан давхардсан тоогоор нийт 310 ажлын байрыг зарлан, 94 ажлын байрыг нөхсөн байна. Төрийн албаны нөөцийг бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг 4 удаа зохион байгуулж, 408 иргэн шалгалтад орсноос 147 иргэн тэнцэж ерөнхий шалгалтын нөөцөд бүртгэгдлээ.	100.0
3.2.Байгууллагын дотоод ажлыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэнэ.							
3.2.1	Байгууллагын болон нэгжийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана.	БӨХ	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	95%	Хагас жил – 95% Бүтэн жил - 100%	Аймгийн Засаг даргатай, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын байгуулах байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 17 зорилт 80 арга хэмжээний хүрээнд , Төсвийн шууд захирагчтай, нэгжийн даргын байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг 14 зорилт 58 арга хэмжээний хүрээнд боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хагас болон бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна	90.0
3.2.2	Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангуулна.	БӨХ	Хэрэгжилтийн хувиар	98%	Хагас жил – 95% Бүтэн жил - 100%	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан нийт ажилтан албан хаагчдаас хөдөлмөрийн дотоод журамд оруулах санал авч боловсруулж, батлуулсан. Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу давхардсан тоогоор 46 ажилтан албан хаагчдын өргөдөл, хүсэлтийг үндэслэн тусламж, дэмжлэг олгон ажиллалаа.	90.0

3.2.3	Аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогчийн өдөр тутмын ажлаа хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж, мэдээ мэдээллээр хангана.	БӨХ	Хэрэгжилтийн хувиар	98%	Хагас жил – 95% Бүтэн жил - 100%	Аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч нарыг өдөр тутам ажлаа хэвийн явуулахад тусалж өгсөн үүрэг даалгавруудыг (хөдөө болон УБ хот явах бүрд бичиг баримт, томилолт) тухай бүр нь шуурхай зохион байгуулан ажилласан. Архив, бичиг хэргийн эрхлэгчээс ирсэн албан бичиг баримтуудыг тухай бүр нь танилцуулж ажилласан. Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 5 удаагийн хуралд сууж, 2 удаагийн хурлын тэмдэглэл бичиж албажуулан ажиллалаа.	100.0
3.2.4	Аймгийн Засаг даргын илтгэл, хэлэх үгийг бэлтгэнэ.	БӨХ	Бэлтгэсэн мэдээ тайлангийн тоо	10	Хагас жил – 10 Бүтэн жил -15	Аймгийн Засаг дарга, орлогч дарга нарт шаардлагатай 15 удаагийн цаг үеийн мэдээлэл, тайланг бэлтгэн хүргүүлсэн.	100.0
3.3.Байгууллагын хэвлэл, мэдээллийн ажлыг хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэнэ.							
3.3.1	Байгууллагын цахим хуудсанд байршуулах мэдээллийн текстийг чанарын өндөр түвшинд боловсруулж, олон нийтэд хүргэнэ.	БӨХ	Цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тоо	10	Хагас жил – 12 Бүтэн жил -24	Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд байршуулах мэдээний текст, фото зургийг бэлтгэн 240 удаа байршуулж олон нийтэд түгээн ажиллалаа.	100.0
3.3.2	Байгууллагын онцлох фото мэдээний текстийг сар бүр чанарын өндөр түвшинд бэлтгэж, байршуулна.	БӨХ	Байршуулсан мэдээний тоо	12	Хагас жил – 6 Бүтэн жил -12	Аймгийн Засаг даргын фото мэдээний самбарыг 24 удаа шинэчилж, 288 мэдээ байршуулж иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна.	100.0
3.3.3	Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг дүрсжүүлж, бэлтгэнэ.	БӨХ	Дүрсжүүлсэн мэдээний тоо	12	Хагас жил – 12 Бүтэн жил -24	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдээс зохион байгуулсан арга хэмжээ, цаг үеийн мэдээ мэдээллийг 48 удаа дүрсжүүлж орон нутгийн гэрээт телевиз болон сайтад байршуулж ажиллалаа.	100.0

3.3.4	Байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг тухай бүр нь шинэчилнэ.	БӨХ	Шинэчилсэн мэдээний тоо	12	Хагас жил – 6 Бүтэн жил -12	Байгууллагын цахим хуудасны мэдээ, мэдээллийг сард 12 удаа шинэчилж ажилласан.	100.0
Зорилт 3.4. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
3.4.1	Архивын баримтыг бүрдүүлж, хадгаламжийн нэгж үүсгэн, зарим баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан үүсгэх ажлыг эрчимжүүлнэ.	БӨХ	Цахимд орсон баримтын тоо	24	Хагас жил –28 Бүтэн жил– 30	Байгууллагын өмнөх онуудын үйл ажиллагаанаас үүссэн 24 цахим баримт дээр 2024 онд үүссэн 7 хадгаламжийн нэгж тухайлбал, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны захирамж 4, боловсон хүчний захирамж 1, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үйл ажиллагааны тушаал 1, боловсон хүчний тушаал 1 тус тус сканердан цахим баримт үүсгэж, нийт 31 цахим баримтаас лавлагаа гарган ажиллаж байна.	100.0
3.4.2	Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулна.	БӨХ	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	Хагас жил –50 Бүтэн жил– 100	Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг 3 удаа хуралдуулж, устгах баримтын жагсаалт, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, Үлгэрчилсэн жагсаалт шинэчлэгдсэнтэй холбоотой баримтын хадгалах хугацаа зэргийг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.	100.0
3.4.3	Байгууллага хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлж, хадгаламж үүсгэнэ.	БӨХ	Хадгаламжийн нэгжийн тоо	2863	Хагас жил - 3113 Бүтэн жил- 3233	Байгууллагын ХХНЖ-ын дагуу хэлтэс болон мэргэжилтнүүдээс хадгаламжийн нэгжүүдийг тодорхой бүрдлийн дагуу хүлээн авч бүртгэлжүүлсэн бөгөөд хадгалах хугацаа дууссан 296 хадгаламжийн нэгжийг устгаж, шинээр 321 хадгаламжийн нэгж хүлээн авч байгууллагын архивт нийт 3739 баримт хадгалан иргэд, ажилчдын хүсэлтийн дагуу лавлагаа мэдээлэл гарган үйлчилж байна.	100.0

3.4.4	Байгууллагад ирсэн, явуулсан бичгийг журам, зааврын дагуу бүртгэн шилжүүлж, шийдвэрлүүлнэ.	БӨХ	Ирсэн бичгийг бүртгэлийн хувь	100%	Хагас жил-100% Бүтэн жил-100%	Ирсэн бичгийн бүртгэлийн дэвтэрт 2066, ERP цахим системд 2058 ирсэн бичиг бүртгэж, удирдлагууд болон хэлтэс, мэргэжилтнүүдэд цаг тухайд нь дамжуулан ажиллалаа. Байгууллагаас явуулсан 1240 албан бичгийг дугаарлан албажуулж, байгууллага, иргэдэд хугацаанд нь хүргүүлсэн байна.	100.0
3.5.Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шуурхай байдлыг хангана.							
3.5.1	Төсөв үр дүнтэй зарцуулж, холбогдох тайлан баланс хугацаанд нь хүргүүлнэ.	БӨХ	Өр авлага үүсгээгүй байдал	100%	Хагас жил-100% Бүтэн жил-100%	Аймгийн Засаг даргын Тамгын газар нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 6137.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого/түрээс/-оор 7.3 сая төгрөг олж , 6145.0 сая төгрөгийн зарцуулалттай , батлагдсан төсвийн хүрээнд үр дүнтэй зарцуулж тайлан баланс гарган сангийн яамны Е тайланд шивэн тайлагнасан.	100.0
3.5.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	БӨХ	Хугацаанд нь бүрэн нийтлэсэн байдал	100%	Хагас жил-100% Бүтэн жил-100%	Байгууллагын санхүүтэй холбоотой гаргасан захирамж, тушаал, төлбөрийн хүсэлт, анхан шатны баримт, 3 дугаар улирлын тайлан баланс, төсвийн гүйцэтгэлийн мэдээ зэргийг цаг тухай бүрд нь шилэн данс болон, байгууллагын ил тод байдлын самбарт байршуулж, 4 дүгээр улирлын тайлан мэдээг хугацаанд нь байршуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	85.9
3.5.3	Харилцагч байгууллагатай гэрээ байгуулж, тооцоо хийж, үр дүнг тооцно.	БӨХ	Хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил-100% Бүтэн жил-100%	Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж, шаардлагатай 8 байгууллагуудтай гэрээ байгуулан, төсөвт тусгагдсан хөрөнгийг хуулийн дагуу зарцуулалт хийж	100.0

						гүйцэтгэлийг тухай бүр нь тайлагнан ажиллаж байна.	
3.5.4	Байгууллагын сүлжээний хурд, аюулгүй байдлыг хангаж ажиллана.	БӨХ	Сүлжээний хурд	30 мвт	40мвт	Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулахаар байгууллагын сүлжээний хурдыг 40 мвт болгон нэмэгдүүлэн ажиллалаа.	100.0
3.5.5	Албан хаагчдын компьютер, техник хэрэгслийг шинэчилж, хэвийн ажиллагааг хангана.	ОНТ1	Техник хэрэгслийн тоо	69	69	Аймгийн Засаг даргын Тамгын газарт принтер 6, хувилагч машин 6, зөөврийн компьютер 19, суурин компьютер 3, лаптоп 10 ширхэг, шинээр худалдан авч тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг хийсэн. Албан хаагчдын ширээ сандал, үйлчилгээний ажилчдын цэвэрлэгээний тоног төхөөрөмж, ажлын хувцас зэргийг бүрэн шинэчилсэн. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын камержуулалтыг шинэчилсэн.	100.0
3.6.Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.							
3.6.1	Гадаадын адил түвшний байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллана.	БӨХ	Хамтын ажиллагааны тоо	5	Хагас жил – 3 Бүтэн жил - 6	Хөрш зэргэлдээ муж улс, хотуудтай хамтран ажиллах, бодлого чиглэлийн хүрээнд 2024 оны 2 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг ОХУ-ын БН Хакас Улс болон БН Тува Улсад албан айлчлал хийж БН Тува Улсын тэргүүн В.Т.Ховалыгтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан. Мөн ОХУ-ын БН Хакас Улстай хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан Гадаад харилцааны яамны гэрээ эрх зүйн газраас гэрээ байгуулах зөвшөөрөл авахаар уламжилсан. ОХУ-ын БНТува Улс, Завхан аймаг хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсгийн цахим хурал, “Тэсийн хөгжил-2024”	100.0

						форум, “Арцсуурь боомтын сэргэлт-2024”, Завхан аймгийн соёлын өдрүүд арга хэмжээ болон ОХУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамтай хамтран “Орос хэлийг хэн сайн мэдэх вэ” баруун бүсийн олимпиадыг зохион байгуулсан.	
3.6.2	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудлаарх зөвшөөрөл, чиглэлийг дээд шатны байгууллагаас авч, хэрэгжилтийг хангана.	БӨХ	Зөвшөөрлийн тоо	2	Хагас жил – 2 Бүтэн жил - 4	Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Хакас Улс руу хийх албан айлчлалын хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны 1/101 дугаартай албан бичгээр зөвшөөрөл авч, удирдамж, хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Гадаад харилцааны яамаар батлуулж, хэрэгжилтийг хангасан.	100.0
3.6.3	Гадаад хөрөнгө оруулалтын хүрээнд орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг нэгдсэн удирдлагаар хангах, тайлан мэдээллийг нэгтгэж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	БӨХ	Тайлан хүргүүлсэн тоо	2	Хагас жил – 1 Бүтэн жил – 2	Гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 5 төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас болон бүтэн жилээр хүлээн авч нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.	100.0
3.6.4	Гадаад харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд орон нутагт хэрэгжих арга хэмжээг зохион байгуулж, тайлагнана.	БӨХ	Арга хэжээний тоо	2	Хагас жил – 1 Бүтэн жил – 1	Гадаад харилцааны чиглэлээр “Тэсийн хөгжил-2024” форум, ОХУ-ын БНТува Улс, Завхан аймаг хооронд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хэсгийн цахим хурал, “Арцсуурь боомтын сэргэлт-2024”, “Тува, Увс, Завхан” 3 талийн бизнес эрхлэгчдийн уулзалт зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Мөн хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд Япон Улсын засгийн газрын буцалтгүй тусламжийн "Өвсний Үндэс" хөтөлбөрийн хүрээнд Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн их	100.0

						засварын ажил, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай байгуулсан гэрээний 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тус тус гарган холбогдох байгууллагуудад тайлагнасан.	
ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ							
4.1.Иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэж, төрийн үйлчилгээг цахимаар түргэн шуурхай хүргэнэ.							
4.1.1	Иргэдээс байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлыг судалж шийдвэрлэн, хариуг хүргүүлнэ.	БӨХ	Шийдвэрлэлтийн хувь	97.9%	Хагас жил – 97.9% Бүтэн жил– 98.0 %	Аймгийн Засаг дарга хандаж гаргасан 115 иргэдийн аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад хандаж гаргасан 28 албан хаагчийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, удирдлагуудад танилцуулан ажиллалаа. Өргөдөл гомдлыг ерp.e-mongolia цахим системд бүртгэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. 105 иргэний өргөдлийг шийдвэрлэж, шийдвэрлэлтийн хувь 91.3-тай байна. Албан хаагчдын өргөдлийн шийдвэрлэлт 92.8 хувьтай байна.	94.6
4.1.2	Засгийн газрын олон нийттэй төвд аймагтай холбоотой гаргасан санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлүүлнэ.	БӨХ	Шийдвэрлэлтийн хувь	100%	Хагас жил– 100% Бүтэн жил– 100 %	Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвөөр дамжин ирсэн 143 өргөдөл гомдлыг хүлээн авсан. Өргөдөл гомдлыг харьяаллын дагуу шилжүүлэн судлуулж, хариуг иргэнд хүргүүлэн ажилласан бөгөөд шийдвэрлэлт 96.5 хувьтай байна.	100.0
4.1.3	Иргэдийн санал хүсэлтийг 7046-1212 утсаар хүлээн авч, шийдвэрлүүлнэ.	БӨХ	Шийдвэрлэлтийн хувь	100%	Хагас жил– 100% Бүтэн жил– 100 %	Иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын 70461212 дугаарын утсаар 960 дуудлага хүлээн авч, илгээх хуудсаар	100.0

						бэлтгэж, удирдлагуудад танилцуулан холбогдох албан тушаалтанд тухайн өдөрт нь шилжүүлж ажиллалаа. Үүнээс 12 иргэний гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллалаа.	
4.1.4	Байгууллагын дарга нарын шуурхай хурлын зар хүргэж, шуурхай хурлаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж танилцуулна.	БӨХ	Биелэлтийн хувь	100%	Хагас жил– 100% Бүтэн жил– 100 %	Байгууллагын дарга нарын шуурхай хурлын 10 удаагийн зарыг хүргэж, шуурхай хурлаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь ХШҮ-ний цахим мэдээллийн санд хуваарилж, үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээр үнэлүүлж ажиллалаа.	100.0
4.1.5	E-mongolia цахим системийн үйлчилгээг эрчимжүүлж, төрийн үйлчилгээг цахимаар хүргэх нөхцөл боломжийг нэмэгдүүлнэ.	БӨХ	Цахимаар төрийн үйлчилгээ авсан иргэдийн хувь	45%	Хагас жил– 45% Бүтэн жил– 60%	Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх зорилгоор Улсын бүртгэлийн хэлтэс, ГХБХБГазар, аймгийн ЗДТГ, Цахилгаан холбоо ХХК, Авто тээврийн төв, Тэс сумын Арц сууль боомт, Нөмрөг, Их-Уул сумын ЗДТГ-уудад тус тус киоск машин шинээр суурилуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.	100.0
4.1.6	Архивын баримтаас иргэн, албан хаагчдын лавлагааны хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэнэ.	БӨХ	Лавлагааны тоо	100	Хагас жил– 50 Бүтэн жил - 100	Архивын баримтаас иргэн, албан хаагчдын лавлагааны 123 хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн 853 хүртэл дугаарлан ХУУЛБАР ҮНЭН дардас дарж баталгаажуулан ажиллалаа.	100.0
Зорилт 4.2.Иргэдийн хүсэлтийн дагуу төрийн шагнал, одон медальд уламжилж, шийдвэрлүүлнэ.							
4.2.1	Төрийн шагналд тодорхойлогдсон иргэн, байгууллагын материалыг хүлээн авч, шийдвэрийг Монгол Улсын	БӨХ	Төрийн шагналд уламжилсан иргэдийн тоо	135	Хагас жил– 60 Бүтэн жил - 135	Монгол улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын дагуу олон жил, үр бүтээлтэй ажиллаж сум, байгууллагаас шагнуулахаар тодорхойлогдож ирсэн 509 иргэдийн	100.0

	Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилна.					материалыг Төрийн дээд шагналаар шагнуулахаар аймгийн Засаг даргад танилцуулж, шийдвэр гаргуулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан. Төрийн шагналд уламжилсан иргэдээс 139 иргэн шагнагдсан байна.	
4.2.2	Алдарт эхийн одонгийн болзол хангасан эхчүүдийн материалыг хүлээн авч, шийдвэрийг гаргуулна.	БӨХ	Алдарт эхийн одонд уламжилсан эхчүүдийн тоо	100	Хагас жил – 100	23 сумын “Алдарт эх”-ийн нэгдүгээр зэргийн одонгийн болзол хангасан 17 эхчүүд, хоёрдугаар зэргийн одонгийн болзол хангасан 181 эхчүүдийн материалыг аймгийн Засаг даргад танилцуулж, шийдвэр гаргуулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан. Ерөнхийлөгчийн зарлигаар Алдарт эх”-ийн нэг, хоёр дугаар зэргийн одонгоор шагнагдсан 198 эхчүүдийн шагналыг ёслол хүндэтгэлтэйгээр гардуулан ажилласан.	100.0
ТАВ. НЭМЭЛТ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ							
5.1	Аймгийн Засаг дарга, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь хэрэгжүүлнэ.	БӨХ	Хэрэгжилтийн хувь, үүрэг даалгаврын тоо	100%	Хагас жил - 100% Бүтэн жил- 100%	Дээд шатны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн цаг тухайд нь хариу тайлагнан ажиллаж байна.	100.0
5.2	Аймгаас зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээ, хурал, зөвлөгөөнд бүрэн идэвхтэй оролцож, хэрэгжилтийг хангаж ажиллана.	БӨХ	Хурал, зөвлөгөөн болон нэгдсэн арга хэмжээнд хамрагдалтын хувь	100%	Хагас жил - 100% Бүтэн жил- 100%	Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй олон нийтийг хамарсан арга хэмжээ, зөвлөгөөнд холбогдох албан тушаалтанг хамруулан хариуцлагатай оролцуулсан.	100.0

5.3	Хяналт-шинжилгээ, үнэлгээний болон зөвлөн туслах баг, холбогдох хэлтсүүдээс өгсөн зөвлөмж, үүрэг чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэн тайлагнана.	БӨХ	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	100%	Хагас жил - 100% Бүтэн жил- 100%	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон аймгийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ 2 удаагийн зөвлөмж ирүүлсэн. Мөн “Оюунлаг таны туслагч” төрийн бус байгууллагаас аймгийн Засаг даргын тамгын газрын авилгын эрсдэлийн үнэлгээний тайланд ирүүлсэн зөвлөмж, үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100.0
5.4	Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан графикийн дагуу мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	БӨХ	Хугацаанд нь хүргүүлсэн тайлангийн хувь	100%	Хагас жил - 100% Бүтэн жил- 100%	Тайлан мэдээний графикийн дагуу тайлан мэдээг хугацаанд нь холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна.	100.0
Нийт							99,3%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР